

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай АЗЗА ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2024/03НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Э.Сүнжидмаа

Утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.14 № 115

танай _____ -ны № _____ -г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Говь-Алтай АЗЗА" ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ. Говь-Алтай АЗЗА ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 220 дугаар тогтоолоор Авто замын засвар арчлалтын төрийн өмчит 20 компанийг нийлүүлэн "Авто замын засвар арчлалтын нэгтгэл" төрийн өмчит хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулах шийдвэр гарсан байна.

Аудитын гол асуудал

Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2020 онд нийлүүлсэн 2 тээврийн хэрэгслийг бүртгэлд тусгаагүй байна. Харин өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн 29,577.4 мянган төгрөгийн, балансаас балансад шилжүүлсэн 10,000.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслийг орлогод авч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 546 тогтоолын дагуу 10,534.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Бусад асуудлын хэсэг

Зам, тээврийн хөгжлийн яамтай 2023 онд байгуулсан засвар арчлалтын гэрээ, болон авто зам хариуцагчийн гэрээний хэрэгжилтийг 85.7 хувьтай үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

0702700379

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	329,615.5	276,635.5
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	801,211.0	746,228.0
Нийт хөрөнгийн дүн	1,130,826.5	1,022,863.5
Нийт өр төлбөрийн дүн	286,054.1	285,415.6
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	844,772.5	737,447.9
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,130,826.5	1,022,863.5
Үйл ажиллагааны орлогын дүн	287,978.0	143,803.9
Үйл ажиллагааны зардлын дүн	316,935.8	193,341.8
Үйл ажиллагааны үр дүн	(-28,957.8)	(-49,537.9)
Үйл ажиллагааны бус үр дүн	7,274.9	
Үйл ажиллагааны нийт үр дүн	(36,232.8)	(-49,537.9)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	879,825.3	776,985.8
Тайлант оны үр дүн	(36,232.8)	(-49,537.9)
Эцсийн үлдэгдэл	844,772.5	737,447.9
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	976,206.8	1,121,594.3
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	981,639.5	1,087,646.7
Үйл ажиллагааны ЦМГ	(5,432.6)	33,947.5
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(60,899.8)	(33,846.5)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	(66,332.4)	101.0
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	998,870.0	993,523.8
Урсгал зардал	998,870.0	993,523.8
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,044,250.0	960,285.1
Улсын төсвөөс санхүүжих		
Орлого	1,044,250.0	960,285.1

Гурав.: АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1 зөрчил¹ илэрч, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Нэг жилээс дээш насжилттай 9,676.8 мянган төгрөгийн авлага, 284,950.8 мянган төгрөгийн өглөг бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Авлага, өглөгийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

/Мянган төгрөгөөр/

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
"Говь-Алтай АЗЗА" ТӨХК	Нэг жилээс дээш насжилттай 9,676.8 мянган төгрөгийн авлага, 284,950.8 мянган төгрөгийн өглөг бүртгэлтэй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-
Нийт		1	-	-	-	1	-	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
"Говь-Алтай АЗЗА" ТӨХК	Худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр 56,948.4 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авалт хийсэн.	1	56,948.4	-	-	1	56,948.4	-	-	-	-
Нийт		1	56,948.4	-	-	1	56,948.4	-	-	-	-